

# SECURITY AT MUSEUMS МУЗЕЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



United Nations  
Educational, Scientific and  
Cultural Organization

**Reproduction is authorized, providing that appropriate mention is made of the source, and a copy sent to the UNESCO (Paris), address below. This document should be cited as:**

**©UNESCO, 2006. Cultural Heritage Protection Handbook.**

**Securtiy at museums, UNESCO, Paris.**

Энэ номыг дахин хэвлэхийг зөвшөөрнө. Гагцхүү эх сурвалжийг дурдаж, нэг хувийг дор заасан ЮНЕСКО (Парис) хаягаар явуулна: Номонд дараах ишлэлийг оруулна: © ЮНЕСКО, 2006. Соёлын өвийг хамгаалах гарын авлага №1. Музейн аюулгүй байдал. ЮНЕСКО, Парис.

**Editor:** **Anna Paolini**

Хянасан:

**Editorial assistants:** **Malda Jabbour, Lise Macdonald**

Хяналтын туслах:

**Text by:** **Adalberto Biasiotti**

Бичсэн:

**Drawings by:** **Beatrice Beccaro Migliorati**

Зурсан:

**Printed in 2007 by the:**

**United Nations Educational, Scientific and Cultural Organisation  
7, place de Fontenoy, 75732 07 SP, France  
© UNESCO 2007  
(CLT/CH/MUS-06/17)**

Англи хэлнээс монгол хэлэнд орчуулсан хоёр дахь хэвлэл.

Англи хэлнээс орчуулсан: Д.Цэдмаа, Х.Эрдэмбилэг  
Хянан тохиолдуулсан: Г.Жаргалсайхан

**МОНЦАМЭ агентлагийн хэвлэлийн газарт  
хэвлүүлэв. Улаанбаатар, 2012 он**

**ISBN 99929-0-366-X**

## INTRODUCTION

—the following instructions are generally applicable in most circumstances.

—please note that the duties pictured here may be assigned to more than one guard.

—please remember that instructions issued by the Museum curator or other person in authority have priority over the indications of this manual.

—always trust your best experience, judgement and skill to handle unusual events or unforeseen circumstances.

## ТАНИЛЦУУЛГА

—дараах заавруудыг ихэнх нөхцөлд байдалд хэрэглэх боломжтой.

—зургаар үзүүлсэн үүрэг хариуцлага музейн хамгаалалтын албаны нэг бус ажилтанд ноогдох ажил байж болно.

—эрх бүхий удирдлагаас батлан гаргасан заавар нь энэ гарын авлагын заавраас илүү эрхтэй.

—гэнэтийн болон урьдчилан тооцоогүй нөхцөл байдалд хуримтлуулсан туршлага, мэдлэг, чадвартаа үргэлж найд.



Museum protection duties never stop—the handover from night duty to daytime duty should be carried out according to agreed procedures, in an orderly and secure manner.

Музейг хамгаалах ажил хэзээ ч зогсдоггүй. Тогтсон дэгийн дагуу баталгаатай, дэс дарааллаар өдөр шөнийн хамгаалалтын ээлжийн ажлыг хүлээндээсэн өгч бай.



Duty starts about half an hour before opening to the public; all emergency exits should be free and the immediate exit area inspected to remove possible obstructions.

Өдрийн хамгаалалтын ээлжийн ажил музейг нээхээс хагас цагийн өмнө эхэлнэ. Аюул ослын үед ашиглах хаалгудын түгжээг тайлж, саад тогтор болох зүйлсийг зайлцуулан гарцуудыг чөлөөтэй болгоно.




Open or unlock all windows and doors that have been secured at night.

Шөнийн цагт хамгаалсан хаалга, цонхны түгжээг тайлж, эсвэл нээ.




Check that all important keys are present or properly accounted for.

Түлхүүрүүд хадгалсан байрандаа тоо ёсоор, бүрэн байгаа эсэхийг шалга.



Read any remarks written in the log-book and take appropriate steps if any.

Жижүүрийн дэвтэрт бичсэн тэмдэглэлүүдийг уншиж, хэрэв шаардлагатай бол арга хэмжээ ав.



Switch off night intrusion detection panel and check regular operation of closed circuit television system, portable alarm transmitter, portable radio sets, public address equipment, first aid kit and emergency equipment.

Шөнийн хөдөлгөөн илрүүлэгчийг унтраа. CCTV систем, дохиолол, радио долгионы төхөөрөмж, зар хүргэх аппарат, эмнэлгийн анхны тусlamжийн хайрцаг болон аюул ослын техник хэрэгслийг шалга.



Check the quality of the recorded images by replaying an accelerated video cassette or digital recorder.

Хяналтын камерт бичигдсэн видео болон дижитал дурс бичлэгүүдийн чанарыг хурдан гүйлгэж шалга.




Check your block note, pen, portable lamp and other personal equipment.

Тэмдэглэлийн дэвтэр, үзэг, гар чийдэн зэрэг бусад хэрэгслүүдийг шалга.



Inspect all artefacts on display and check that all are accounted for and secured.

Үзүүллэгт тавьсан бүх үзмэрүүд тоо ёсоор бүрэн бүтэн байгаа эсэхийг шалга.



If any artefacts are missing, check that the appropriate label, with duly authorized signature, is applied on site.

Зарим үзмэр байхгүй байгаа бол хариуцсан ажилтан нь гарын үсэг зурсан орлуулах карт зохих журмын дагуу байгаа эсэхийг шалга.




Look for artefacts accidentally moved or in a dangerous position; **do not touch artefacts**. Ask a specialist to rectify the situation.

Үзмэр байрнаасаа хөдөлж, гэмтэж болзошгүй байрласан бол **үзмэрт гар хүрч болохгүй**. Хариуцсан мэргэжилтэнд хандаж байрлалыг засуул.



Ask a specialist to rectify the situation; artefacts should always be moved by skilled people wearing gloves and taking special precautions.

Үзмэрийг хариуцсан мэргэжилтэнд хандаж байрлалыг засуулах нь зүйтэй. Дадлагжсан мэргэжилтнүүд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, бээлий өмсөж үзмэрийг засч байрлуулна.



Please remember that water and fire are the two greatest risks in a museum.

Ус, гал хоёр бол музейд хамгийн их аюул учруулна гэдгийг байнга сана.



Look for possible water damage.

Ус алдах магадлалтай газрыг сайн шалга.




Avoid large piles of flammable packing materials; inform supervisor and ask for them to be removed.

Галд амархан шатах зүйлсийг нэг дор овоолохоос болгоомжил. Ахлахдаа мэдэгдэж, овоорсон зүйлсийг зөөж холдуулахыг хүсэх нь зүйтэй.




Check location of all portable extinguishers and...

Бүх зөөврийн гал унтраагчийн байрлалыг шалга. Мөн...




... state of operation.

...ажиллаж байгаа эсэхийг шалга.




Check location and state of fire alarm buttons.

Галын дуут дохиог шалга.



Check electrical connection wires and report any faulty or damaged wiring immediately.

Цахилгаан утасны холболтуудыг шалгаж, ямар нэг гэмтэл илэрвэл яаралтай мэдэгд.



Check the contents of all first aid kits installed in the exhibition rooms.

Үзүүллэгийн танхимд байрлуулсан эмнэлэгийн анхны тусlamжийн хайрцган дахь зүйлс бүрэн байгаа эсэхийг шалга.



Check that all internal phones are in working order.

Утасны дотоод сүлжээ хэвийн ажиллаж байгааг шалга.




Check the free field of vision of CCTV cameras.

CCTV камерийн тусгалд ороогүй газруудыг шалга.




Monitor cleaning operations and occasionally check contents of trash bins.

Цэвэрлэгээний байдлыг хянаж, хогийн сав доторхийг үе үе үзэж бай.




Report any bulbs that have blown.

Шатсан гэрлийн чийдэнг тэмдэглэж мэдэгд.




Fix minor disruptions, if possible, or report to appropriate service.

Боломжтой бол хэвийн бус байгаа жижиг зүйлсийг янзал, эсвэл холбогдох албанд мэдэгд.




Check for any trash left on site and report to appropriate service.

Музейд орхисон хог хаягдлыг шалгаж, холбогдох албанд мэдэгд.



Carefully identify visiting scholars and third parties, before granting a visitor pass, to be constantly displayed while on museum premises.

Түр ажиллах судлаач, эрдэмтэд болон бусад хүмүүст музейд байхдаа байнга зүүх нэвтрэх үнэмлэх олгохосоо өмнө сайтар судалж, таних хэрэгтэй.



Closely monitor all loading and unloading operations.

Ачаа ачих, буулгах үед дэргэд нь байлцан бүх үйл ажиллагааг хяна.



Monitor and, if necessary, prevent activities, in immediate museum surroundings, that may be a source of danger – if appropriate, call police for help.

Музейн эргэн тойронд аюулын эх үүсвэр байгаа эсэхийг хянаж, шаардлагатай бол урьдчилан сэргийлж, мөн цагдаагийн тусламж хүс.



Monitor the activities of conservators, graphic artists and so on; if necessary, temporarily restrict access to the exhibition room where work is being performed.

Үзмэр арчлан хамгаалагч, график дизайнер гэх зэрэг хүмүүсийн ажлыг хянаж, шаардлагатай бол үзүүллэгийн танхимд үзэгчид орохыг түр хязгаарала.




If you use keys, giving access to showcases or other critical containers, do not let anybody handle the key on your behalf, or even see it.

Хэрэв та хорго ба бусад чухал зүйлийн тулхүүр хариуцсан бол бусдад тулхүүрээ шилжүүлж болохгүй. Үзүүлсний ч хэрэггүй.



Profile keys may be easily copied by making a quick impression with wax or soap.

Лаа, саван ашиглаж тулхүүрийн хэвийг амархан авдаг.



Even the codes of high security double bitted keys, used on safes, may be captured by a skilled observer.

Хамгаалалт сайтай сейфний давхар далаавчтай тулхүүрийг ч мэргэшсэн хүн хараад л хувилж чадна.




Be ready to open museum doors at stated time – it is an essential act of courtesy to visitors.

Музейг цагийн хуваарийн дагуу яг цагт нь нээж байх нь үзэгчдээ хүндэлж байгаа хэрэг.



Gently but firmly, ask visitors to leave at the entrance all personal items that can cause damage to objects or may be used to hide and take these away.

Үзмэр нууж авч гарах боломжтой эсвэл гэмтээж мэдэх том хэмжээтэй зүйлийг музейд орохдоо үүдэнд хадгалуулах шаардлагатайг үзэгчдэд эелдгээр, нухацтай хэлэх хэрэгтэй.




A museum is a temple of our cultural heritage – do not let unruly or improperly dressed visitors desecrate it.

Музей бол бидний соёлын өвийн ариун сүм учраас зохисгүй, бохир хувцасласан хүмүүсийг оруулахгүй байх нь зүйтэй.



Be ready to help disabled visitors, giving assistance and directions – be careful not to be distracted from your main duty which is to protect exhibits.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусалж, зүг зааж өгч бай. Гэхдээ үзмэр хамгаалах гол үүргээ умартаж болохгүй.




Keep an attentive eye on visitors during opening hours, to detect early signs of potential trouble or improper behaviour.

Гарч болох аюул, зүй бус үйлдлийг цаг алдалгүй илрүүлэхийн тулд музей нээлттэй байх үед үзэгчдийг байнга ажиглах шаардлагатай.



Try to find a strategic observation point and move often, constantly taking different paths and at different times.

Бүгдийг ажиглаж болохуйц цэг олж зогсоод, байнга өөр өөр цагт, янз бүрийн замаар явж шалгалт хий.



It takes only seconds to damage a painting with a portable spray can, or...

Жижиг савтай шингэн шуршигчээр уран зургийг хэдхэн хормын дотор гэмтээж болно, эсвэл...




... to scratch a valuable portrait.

...хоромхон хугацаанд ховор нандин зургийг сараачиж гэмтээж болно.



Prevent visitors from using flashes if photographing is authorized – explain that excessive light may irreversibly damage delicate organic-based colours and disturb other visitors.

Хэдийгээр гэрэл зураг авах зөвшөөрөлтэй ч гэрэл цацруулж бүү зураг авахуул. Цочмог хурц гэрэл нь органик бүтэцтэй хэврэг будгийн өнгийг гэмтээх бөгөөд мөн бусад үзэгчдийн тав тухыг алдагдуулдаг гэдгийг тухайн хүнд тайлбарла.



Prevent visitors from using tripods, during picture-taking (if authorized) – the tripod may interfere with the free flow of visitors and slow down rapid exit, in case of emergency.

Үзэгч гэрэл зураг авахдаа (хэрэв зөвшөөрөлтэй бол) тулгуур хөл хэрэглэхийг хоригло. Энэ нь үзэгчдийн хөдөлгөөний урсгалыг удаашруулахаас гадна аюул ослын үед музейгээс түргэн гарахад саад бэрхшээл болно.




Do not let visitors touch artefacts of any kind – even metal can be damaged by corrosion from natural skin oils.

Үзэгчдийг ямар ч үзмэрт гар хүрэхийг хоригло. Тэмэр зүйл ч гэсэн хүний арьснаас ялгарах тосонд бохирдож гэмтэнэ.



Strictly enforce a no – smoking policy; fire is a major risk for artefacts displayed in a museum.

Галын аюул бол үзмэрт хамгийн их аюул учруулдаг зүйлийн нэг учраас музейд тамхи татахыг хоригло.




Gently yet firmly stop visitors from using exits which should be used only in emergencies.

Аюул ослын үед ашиглах хаалгаар энгийн үед үзэгч орж гарч болохгүйг эзлдэг, нухацтай хэлж хоригло.




Do not allow visitors to bring food and bottles into the museum; bottles may break and food may spill on museum floors.

Хоол хүнс, шилэн лонх музейд бүү оруул.  
Шилэн лонх хагарч, хоол хүнс шалан  
дээр асгарч мэднэ.



Show visitors where they may eat and drink – check that trash is thrown in bins.

Үзэгчдэд хоол хүнсээ хэрэглэх,  
түр хадгалах газрыг зааж өг. Мөн  
хэрэглэсэн зүйлсээ хогийн саванд  
хийсэн эсэхийг шалга.



If you notice a suspicious bag or package in the museum ...

Хэрэв та сэжигтэй уут сав, боодол баглаа музейд харвал...



...gently but firmly ask all visitors to leave, restrict access to the risk area and call for appropriate support.

...музейгээстүргэн гарахыг бүх үзэгчдэд эелдэг, нухацтай хэлж, эрсдэлтэй талбайд хүн оруулахгүй байх арга хэмжээ авч, тусlamж дууд.




Young visitors are the future custodians of our cultural heritage, but...

Хүүхдүүд бол бидний соёлын өвийн ирээдүйн эзэд мөн. Гэхдээ...



...contact the school master, give advice and directions, discreetly monitor children's behaviour. If necessary, call for additional support.

...сургуулийн багштай нь уулзаж, музейг хүүхдүүдэд хэрхэн үзүүлэх талаар удирдамж, зөвлөмж өг. Хүүхдүүдийг сэмхэн ажиглаж, шаардлагатай бол нэмэлт тусламж ав.



Watch for children and visitors chewing gum; often the gum is found attached to the underside of artefacts.

Бохь зажилж байгаа хүүхэд болон үзэгчдийг анзаар. Учир нь үзмэрийн далдхэсэгт бохь наалдуулсан тохиолдол гардаг.




Discreetly, but carefully, watch children's behaviour; the natural curiosity of children may lead to artefacts being touched or scratched, with possible consequential damage.

Хүүхдүүдийн хөдөлгөөнийг нууцаар анхааралтай ажиглаж бай. Хүүхэд төрөлхийн сониуч зангаараа үзмэрт хүрч, хатгаж, сараачих зэргээр гэмтээх тохиолдол байдаг.




Please always remember that your primary duty is to protect the museum collection; if questioned by a visitor, give answers only related to museum facilities and rules; you are a guard, not a tourist guide.

Таны гол үүрэг бол музейн цуглуулгыг хамгаалах гэдгийг бүү умарт. Хэрэв үзэгч асуулт асуувал зөвхөн музейн дүрэм журам, байршилын талаар мэдээлэл өг. Та бол хамгаалалтын албаны ажилтан болохоос хөтөч тайлбарлагч биш билээ.




Keep an especially attentive eye on small items that can easily be removed, such as an antique vase cover, for instance, or...

Хүн аваад явчихаж болох жижиг үзмэрийг их анхаар. Жишээлбэл, эртний ваарны таглаа гэх зэрэг зүйлс байж болно. Эсвэл...



...the hands of a clock, or...

...цагын зүү ч байж болно. Эсвэл...



...a key and a keyhole cover.

...тулхүүр ба түгжээний хаалт ч байж болох юм.




Be ever alert and attentive; if you need to leave your duty post for a moment, ask to be replaced.

Байнга сонор сээрэмжтэй, анхааралтай бай. Хэрэв та ажлын байраа түр орхих шаардлагатай бол орлуулах хүн дууд.



If no visitor is present, you may rest on appropriate collapsible chairs.

Үзэгчгүй байх үед зориулалтын сандал дээр сууж, амарч болно.



Never rest on artefacts on show.

Үзүүллэгт дэглэн тавьсан үзмэр дээр хэрхэвч сууж болохгүй.



Be always ready to use the internal phone to call for support.

Утасны дотоод служээг ашиглаж тусламж дуудахад ямагт бэлэн бай.



Be always ready to use a portable fire extinguisher.

Зөөврийн гал унтраагчийг ашиглахад ямагт бэлэн бай.



If a visitor should have an accident...

Хэрэв үзэгч гэмтэж бэртвэл...



...keep other people at a distance and call for professional first aid.

...бусад хүмүүсийг зайдуу байлгаж, эмнэлгийн яаралтай тусламж дууд.




When the paramedics arrive, interview witnesses and record all the relevant facts.

Эмнэлгийн тусламж ирсний дараа бүх болсон явдлыг тэмдэглэж, гэрчүүдээс ярилцлага ав.



At appointed time, gently yet firmly escort all visitors to the exit.

Цагийн хуваарийн дагуу хаах цагтаа үзэгчдийг эелдгээр хаалгаар үдэж гарга.



Strictly refrain from accepting gratuities of any kind; if appropriate, propose a donation to support museum activities.

Үзэгчдээс гарын бэлэг авч болохгүй. Харин зохимжтой бол, музейн үйл ажиллагааг дэмжих хандив өгөхийг санал болго.



Put all the museum exits under lock and key.

Музей хаасны дараа бүх хаалгыг түгж.



Lock all windows.

Бүх цонхыг түгж.



Inspect all exhibition rooms.

Бүх үзүүллэгийн танхимыг шалга.




Check all intrusion detector devices by observing the blinking light reaction to your movements (if appropriate).

Хөдөлгөөн илрүүлэгч төхөөрөмжийн дохионы гэрэл нь өөрийн чинь хөдөлгөөнийг мэдэрч байгааг (хэрэв боломжтой бол) шалга.




Inspect all service rooms and toilets.

Үйлчилгээний ба бие засах өрөөнүүдийг шалга.




Check that all main keys are present or properly accounted for.

Чухал шаардлагатай тулхүүрүүд тоо ёсоор, бүрэн байгаа эсэхийг шалга.



Write any information about your day shift in the logbook for the information of the night guards.

Өдрийн ээлжийн хугацаанд болсон үйл явдлуудыг жижүүрийн дэвтэрт бичиж шөнийн ээлжинд мэдээл.



Turn on the night intrusion detection control panel; check that all security equipment is working properly.

Шөнийн хөдөлгөөн илрүүлэгчийн хяналтыг самбарыг асааж, бусад дохиолол хамгаалалтын хэрэгслүүд ажиллаж байгааг эсэхийг шалга.



Perform night shift exchange of duties, according to relevant procedures.

Холбогдох зааврын дагуу шөнийн ээлжинд ажил үүргээ хулээлгэн өгөх хэрэгтэй.




If appropriate, carry out the night shift watch tour by checking the areas for inspection in the sequence indicated here.

Хэрэв тохирохоор бол, энэ зааварт үзүүлсэн дарааллын дагуу шөнийн ээлжний шалгалтыг хий.



Check the important areas once again as indicated in this handbook.

Энэ зааварт заасны дагуу онцгой газруудыг дахин сайн шалга.



If there is a watch recorder, set to planned schedule.

Дүрс бичлэгийн тэхөөрөмжийг төлөвлөсөн хуваарийн дагуу тохируул.

